

Ган хийц ХК-ийн 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн
хурлын материалын хавсралт



ГАН ХИЙЦ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2024.04.12

Ган хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 11:40 минут компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Л.Чинбат, Ц.Лувсандорж, Х.Эрдэнэсанаа нар оролцлоо.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 72,22% буюу 175113 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, нарийн бичгийн даргаар О.Ууганцэцэг

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 11:50 минут эхэлж, 12:50 цагт дуусгахыг санал оруулж батлууллаа.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. Хуралд оролцсон бүх гишүүд 100 хувь саналаар зөвшөөрөв.

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах
2. Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
4. ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв, Компанийн 2024 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах

Хэлэлцсэн нь:

Хэлэлцэх асуудлын дараалалын дагуу **ТУЗ-ийн хийсэн ажлын тайлан болон компанийн үйл ажиллагааны талаарх** мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав. Тайлан дараах чиглэлээр тайланг танилцуулав.

Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг танилцуулах
Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв, Компанийн 2024 оны захиргаа, үйлчилгээний
зардлын төсвийг батлах

2023 онд Ган хийц ХК-ийн Төмөр хийцийн үйлдвэр төслийн борлуулалтын орлого 6,5 тэрбум төгрөг, худалдааны борлуулалтын орлого 125,7 сая төгрөг, төмөр хийцийн үйлдвэрлэлийн борлуулалтын орлого 2,3 тэрбум төгрөг, зургийн ажил 16,1 сая төгрөг, бусад борлуулалтын орлого 189,4 сая төгрөг, түрээсийн орлого 54,3 сая төгрөг болсон бөгөөд нийт 8,3 тэрбум төгрөгийн борлуулалттай ажилласан байна.

Борлуулалтын орлогыг харилцагчаар харуулбал Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын барилга угсралтын ажил 64,1%, Ньюком проперт ХХК 19,0%, Мобиком ХХК 12,2% гэх мэт байгууллагууд томоохон борлуулалтыг эзэлсэн байна.

2022, 2023 оны борлуулалтын орлогыг харьцуулсан байдлаар харуулхад 2023 онд төслийн борлуулалтын орлого их байгаа нь харагдаж байна.

Удирдлага болон үйл ажиллагааны зардал 1,001,952,050 төгрөгийн зардал гарсан байна. 2023 онд татвар, нийгмийн даатгалын зардлыг харуулсан. Та бүхэн танилцаарай. Санхүүгийн дүгнэлтийг харууллаа.

1. Нийт борлуулалтын орлогын 52,71%-ийг Худалдааны салбараас бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч уг салбарын үйл ажиллагааг зогсоосон нь тайлант хугацааны төлөвлөсөн борлуулалтын орлого тасрахад сөрөг нөлөө үзүүлсэн байна.
2. Өмнөх онуудад хүлээн авсан орлого /Дорнод төсөл-3,688,136.8/-ыг хойшлуулж тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрсөн нь орлогын гүйцэтгэлийг 45%-иар, ББӨ-н гүйцэтгэлийг 50,7%-иар, НӨАТ-ын өглөгийг 46,6 хувиар өсгөж байна.
3. Удирдлагын зардлын борлуулалтанд эзлэх хувь 12,03% байна, үүнээс 43,04% нь ажилагсадын цалин, НДШ-н зардал, 17% нь зээлийн хүүгийн зардал, 10,7, хувь нь элэгдлийн зардал, 30% нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал байна.
4. Орлогын тайлангаар Үндсэн үйл ажиллагааны орлого 8,273,251.45, үндсэн бус үйл ажиллагааны орлого 43,522.52, нийт татвар ногдох **орлого 8,316,750.20, ББӨртөг 7,266,919.15**, ерөнхий удирдлага, санхүүгийн зардал 1,001,952.06, үндсэн бус үйл ажиллагааны зардал 69,839.74, Үндсэн хөрөнгө данснаас хассан гарз 59,358.84 буюу тайлант хугацаанд **136,831.37** алдагдалтай ажиллаж 10,263.02 төгрөгийн ОАТ хүлээн зөвшөөрсөн байна.
5. Нийт авлага 2022 онтой харьцуулахад 13,6%-иар өссөн байна, үүнээс 6,4% нь харилцан хамааралтай компаниас авах авлага, 93,6% нь бусад харилцагчаас авах авлага байна.
6. Нийт өглөг 2022 онтой харьцуулахад 46,4%-иар буурсан байна, Дансны өглөг өмнөх онтой харьцуулахад 3,8%, огино хугацаат зээл 43,6%-иар буурсан, татвар, НДШ-ийн өглөг 442% буюу 4,4 дахин өссөн байна

Хоёрдугаар асуудал: Ногдол ашгийн талаар ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 02 дугаартай тогтоолоор 2023 оны санхүүгийн тайлан -136,831,370 төгрөгийн алдагдалтай гарсан тул 2023 оны үйл ажиллагаанд ногдол ашиг тараахгүйгээр шийдвэрлэсэн.

Гуравдугаар асуудал: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны тайлан

2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд өөрчлөгдсөнтэй холбогдуулан дэргэдэх хороодыг шинэчлэн байгуулсан бөгөөд дараах ажлуудыг зохион байгуулсан.

- Ган хийц ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Компанийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй бөгөөд ердийн гишүүд 6, хараат бус гишүүд 3-тай ажиллаж байна.
- Аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороо гэсэн 3 хороотой үйл ажиллагаа явуулж байна.
- Тухай бүр шаардлагатай хурлуудыг зарлан хуралдуулж, холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан.
- Хөрөнгийн биржийн цахим системд мэдээллийг тухай бүр мэдээлэн ажиллаж байна.
- Хагас жил, жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлэн ажилласан.
- Тус хороо нь 2023 онд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж, төлөвлөгөөний дагуу хийсэн ажлын тайланг танилцуулсан.
- Тайлат онд тухай бүр компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичилттэй танилцаж, нягтлан бодох бүртгэлийн бичилтүүдийн талаар зөвлөгөөг өгсөн.
- Компанийн үндсэн хөрөнгийн элэгдүүлэлт бүртгэл хөтлөлттэй танилцаж, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч нарт санал солилцож зөвлөгөө өгч ажиллалаа.
- Компанийн нягтлан бодох бүртгэл аккураил сууриар бүтгэгддэгийг анхаарч ажил үйлчилгээг үзүүлсэн тухай бүрийд нягтлан бодох бүртгэлд бичилт хийхийг зөвлөв.
- Өр авлагыг бууруулах талаар эрчимтэй хөөцөлдөж барагдуулахыг зөвлөсөн.
- Компанийн санхүүгийн бодлогыг баримт бичигтэй танилцсан. Санхүүгийн бодлогын баримт бичиш нь хуучирсан тул шинэчлэх шаардлагатай. Компанийн

НББ-ийн бичиг баримтанд нэмж оруулах, засч сайжруулах санал төслөө бичиж өгсөн.

- Харилцан хамаарал бүхий компаниудтай хийсэн тооцоог баталгаажуулах, нягтлан бодох бүртгэлд бичилт хийхийг анхааруулсан.
- Ган хийц ХК-ийн очиж ажиллаж, ерөнхий нягтлан бодогчтой сар бүр утсаар холбогдож, НББ талаар санал солилцож, зөвлөгөө өгч ажилласан.
- Ногдол ашгийн бодлогыг боловсруулан батлуулав.
- 2021, 2022 онууд нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бөгөөд үүнийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвтэй 2024 онд гэрээг хийж, ногдол ашгийг шилжүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.
- 2021 оны 117 хувьцаа эзэмшигчийн 17,284 ширхэг хувьцаанд 1,614,680 төгрөгийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараасан.
- 2022 оны 119 хувьцаа эзэмшигчийн 17,284 ширхэг хувьцаанд 1,624,625 төгрөгийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан тараасан.
- Санхүүгийн зохицуулах хорооны ногдол ашгийн бүргэлийн мэдээлэлд 2021, 2022, 2023 оны ногдол ашгийг бүртгэлийг оруулсан.
- 2024.04.05-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар дараах журмыг шинэчлэн батлуулав. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам
 - ☐ Аудитын хорооны журам
 - ☐ Нэр дэвшүүлэх хорооны журам
 - ☐ Цалин урамшууллын хорооны журам
 - ☐ ТУЗ-ийн нарийн бичгийн ажиллах журам
 - ☐ Ногдол ашгийн бодлого
 - ☐ Мэдээллийн ил тод байдлын журам
 - ☐ Ёс зүйн дүрэм
- Байгууллагын вэбсайтад ил тод нээлттэй байршуулсан.

2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрөөр тасалбар болгон хувьцаа эзэмшигчийн жагсаалтыг авсан бөгөөд манай компанийн хувьцаа нь 30 брокерын компаниудад 242464 ширхэг хувьцаа байршдаг бөгөөд хамгийн их хувьцаа нь Тулгатчандмань баян ҮЦК, Би ди сек ҮЦК брокерийн компаниудад байршсан байна.

Дөрөвдүгээр асуудал: ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв, Компанийн 2024 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах

2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд Гүйцэтгэх захиралын танилцуулсан ТУЗ-ийн 2024 оны зардлын төсөв, Компанийн 2024 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийн та бүхэнд танилцуулж байна. Дараах байдлаар төлөвлөсөн байна.

2024 онд 500 тонн төмөр хийц үйлдвэрлэж, Борлуулалтын орлогыг 9,089,657,100 төгрөг, Борлуулсан бүтээгдэхүүний орлого 6,423,963,400 төгрөг, ТУЗ-ийн зардал 161,625,600 төгрөг, Захиргаа удирдлагын зардал 1,261,797,400 төгрөг *Хавсралтаар холбогдох зардлын дэлгэрэнгүйг орууллаа.*

Анхаарал хандуулсан баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууслаа та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Х.Эрдэнэсанаа: үйл ажиллагааны тайлан, төсөвтэй танилцлаа. Холбогдох асуудлаар саналгүй болно.

Чинбат: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх санал байхгүй. 2024 оны төсөв дээр нэмэх санал алга байна.

Лувсандорж: Хэлэлцэж байгаа асуудлууд бүгд тодорхой, танилцуулагдсан тул татгалзах, асууж тодруулах зүйл байхгүй байна. Дэмжиж байна.

М.Даваасүрэн: Өөр асууж тодруулах зүйл байна уу. Байхгүй бол Тооллогын комисс байгуулж, ажилд нь оруулъя. Тооллогын комиссыг дараах хүмүүсийг сонгох саналтай байна. Энд байгаа хүмүүс тооллогын комисст орж болохгүй тул менежер, нягтлан бодогч нараас сонгох саналтай байна.

Тооллогын комиссын даргаар

/Х.Ариунсанаа /

Гишүүд

/ З.Алтанхуяг/

/ С.Лхамцэрэн /

Тооллогын комисс бол 4 асуудал дээр гурван санал хуудас хэвлэж санал хураалт явуулна.

Хурлын дарга М.Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тарааж өгнө үү. Ирсэн хувьцаа эзэмшигчид саналыг хуудсыг бөглөв./

Тооллогын комиссын дарга Х.Ариунсанаа саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /протокол, тогтоолыг хавсаргав./

Шийдвэрлэсэн нь:

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 онд хийж гүйцэтгэсэн ажлыг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
6. 2024 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 161,625,600 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2024 оны төсвийг 1,261,797,400 төгрөгөөр батлав.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. / тогтоолыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2024 оны 04 дүгээр сарын 12 өдрийн 13:50 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

Нарийн бичгийн дарга



О.Ууганцэцэг

Танилцсан:

Хурлын дарга



М.Даваасүрэн